

Говьсүмбэр Политехник коллеж

**Шламены аргыг ашиглан
англи хэлний заах арга зүйг
сайжруулах нь**

Англи хэлний багш: А.Золжаргал

2019

1

Шламены аргыг ашиглан Англи хэлний заах арга зүйг сайжруулах нь

Судалгааны үндэслэл

Хэлтэй бол хөлтэй гэсэн монгол ардын зүйр үгээр энэ илтгэлээ эхлүүлбэ. Манай өвөг дээдэс энэ зүйр үгийг зүгээр ч нэг хэлчээгүй бизээ. Дэлхийн улс орнууд аль эрт дээр үеэс худалдаа наймаа, аялал жуулчлал гээл бүхий хүний харилцаанд ордог салбар болгоноор харилцаж ирсэн ба тэдгээр хүмүүсийг холбох ганц хэрэгсэл нь орчуулагч хэлмэрч нар байжээ. Хүн төрлөхтний нийгмийн харилцаанд дахь цар хүрээ өөржиж, хүн бүр гадаад хэл сурах шаардлага нэмэгдэж энэ ч тэд нарт илүү боломжийг өгдөг болжээ. Миний бодлоор одоо гадаад хэлээр чөлөөтэй ярьж сурахыг хүсэж тэмүүлсэн хүмүүс ч олон байна өөрсдийн сурах арга барилыг олоод гадаад хэлээр чөлөөтэй ярьж чаддаг хүмүүс ч олон байна. Надад нэг л маш ойлогомжгүй зүйл байдаг энэ маань юу вэ гэхлээр бид нарт бага байхад хэлд оруулах гэж эхлээд хэлний дүрэм үсэг заасангүй бид хүмүүсийн хэлж ярьж байгааг сонсоод л мөн даган л дууриаж хэлсээр байгаад ярьж сурдаг шүү дээ. Тэгүүл бид нар яагаад хэлийг дунд сургуульд, их сургуульд сурсантайгаа нийлүүлээд барат л ихэнх нь 3-аас дээш жил үзэж байна гэтэл дийлэнх нь нүүлгүй хэлхэд тийм ч сайн биш байдаг энэ юунаас боловоо гадаад хэл зааж байгаа башаас уу, хичээлийн программ эсвэл бид нар гадаад хэл сурах барил муу эзэмшээд хөлболой юу? Гадаад хэлийг эх орондоо кааж сайн сурах вэ? Би баш хүн бидний ирээдүй болсон хүүүхэд залуучуудад яаж заах вэ гэсэн бодлоос энэхүү судалгааг хийлээ.

Судалгааны зорилт

- Гадаад хэл зааж байгаа оюутнууд маань ямар түвшинд байна вэ?
- Гадаад хэлийг ямар зорилгоор сурахыг хүсч байна вэ?
- Гадаад хэл сурахад ямар бэрхшээл байгаа?
- Гадаад хэлийг ямар аргаар заах вэ? гэсэн асуудал дэвшүүлэн дараах хүрээнд асуулга болон туршилтын аргаар судаллаа

Судалгаанд хамрах хүрээ

- Техникчийн боловсролын 1 анги буюу 20 суралцагчийг хамруулсан.

Онолын хэсэг

"Гадаад хэл сурах 4-н чадамж байдал унших, бичих, ярих, сонсох гэсэн. Хүн бүрийн сурах арга барил маш ондоо байдаг. 1001 шөнийн үлгэр байдалтай адил гадаад хэлийг бие даан сурах 1001 арга байдаг гэж хэлж болно. Хүн бүр өөр өөрийн аргаар сурацдаг. Өнөөдөр бид хэл шинжлэлийн ухаанд бие даан сурацдах өвөрмөц нэгэн аргыг нэвтрүүлсэн Шлиманы тухай ярих болно. Юуны өмнө Шлиман гэж хэн байв гэдгийн талаар хэдэн үг хэлбэ. "Генрих Шлиман /1822-1890/ нь 19-р зуунд амьдарч байсан "Германы эрдэмтэн. Тэрбээр Эртний Грекийн үлгэр домогт гардаг Трой хотыг газрын хөрсөн дороос малтаж гаргаад ирсэн гавьяатай хүн.

"Гомерын "Илиад", "Одиссей" зохиолуудад гардаг Трой хотын балгас одоогийн Турк улсын "Иссарлык тосгоны нутаг дэвсгэр дээрээс олджээ. Шлиман нь Эртний Грекийн үлгэр домогт гардаг үйл явдлууд эрт дээр үед болж өнгөрсөн гэдгийг батлах гэж бүхий л амьдралаа зориулсан эрдэмтэн хүн байжээ.

Шлиман Трой хотын балгасыг малтаж байхдаа маш их алтан эдлэл олж "Приам хааны эрдэнэсийн сан" гэж нэрлээд герман, франц хэл дээр олдворынхоо тухай "Итака, Пелопоннес ба Трой" гэдэг номондоо бичжээ. Гэтэл хэвлэл мэдээллийнхнээс түүнийг "Трой хотыг оллоо" гэж дэлхий даяар мандуулж байхад эрдэмтэд дотроос нэг ч хүн түүнийг нь үнэлээгүй орхижээ. Английн археологич "Говард Картер, Карнафон нар маш олон алтан эдлэл агуулсан Эртний Египетийн Тутанхамон хааны бүлшийг олж насан туршдаа алдар нэрээ цуурайтуулж явсан бол Трой хотын балгасаас түүнээс хамаагүй илүү алт олсон Шлиманыг үеийнхэн нь ерөөхөөсөө илүү харааж ирсэн байх юм. Түүний олдворыг үгүйсгэх шалтгаан нь юу байсан бэ гэхэд тэр үед Шлиман нь дээд боловсрол байтугай арван жилийн сургууль төгсөөгүй хүн байжээ. Хэдийгээр археологийн шинжлэх ухаанд нээлт хийсэн боловч үеийнхнээ эрдэмтдийн хүрээнд бүтээлээ хүлээн зөвшөөрүүлж чадаагүй учир Францын Сорбоны их сургуульд 40 гаруй насандаа оюутан болж дэлхийн урлагийн түүх, археологи, санскрит хэл болон дүрс үсгийн талаар сурацдах болжээ. Үдэлгүй хоёрдхь номоо таван хэлээр нэгэн зэрэг хэвлүүлж түүхийн ухааны доктор болсон байна. "Илиад" зохиолд гардаг Грекийн жанжин Агамемноны бүлшийг хайж явахдаа алтан маск олж Эртний Грекийн өмнөх Микены соёл иргэншилийг нээж Английн Оксфордын их сургуулийн хүндэт доктор, Францын Сорбоны их сургуулийн доктор, Герман улсын Ростох хотын их сургуулийн түүхийн ухааны доктор болж байжээ. Шлиман 10 ном бичиж үлдээсэн эрдэмтэн юм. Тэрбээр "Хятад ба Япон орноор аялсан минь" хэмээх анхныхаа номыг франц хэлээр хэвлүүлэн гаргажээ. Үүнээс хойш бичсэн ном бүрээ 3-5 хэл дээр нэгэн зэрэг бичиж хэвлүүлж байжээ. Шлиман дэлхийг тойрсон хүн. Тэрбээр очсон газрынхаа хүмүүстэй төрөлх хэлээр нь ярихаас гадна өдрийн тэмдэглэлээ тэр хэлээр нь бичиж үлдээсэн байна.

Шлиман дэлхийн 17 хэлээр чөлөөтэй ярьж, бичиж эрдмийнхээ бүтээлийг туурвиж байжээ. Батшаар ердөө хоёр хэлийг, тухайлбал санскрит болон эртний Грек хэлийг заалгаж бусдыг нь бие даан сурацжээ. Энэ хүн ийм олон хэлийг яаж бие даан

сүрч чадав гэдгийг сонирхуулахад ердөө л "унш, унш бас дахин унш" гэдэг аргыг хэрэглэсэн байна. Шлиманы аргын онцлог нь унших үйлдлийг бүтээлч үйл ажиллагаа болгосонд оршдог. Тэр хамгийн түрүүнд голланд хэл сурчээ. Голланд хэл нь герман хэлний группт ордог тул амархан сурсан гэдэг. Голланд хэлнийхээ дараа англи хэл сурсан байна. Англи хэл нь түүний хамгийн удаан хугацаагаар сурсан цорын ганц хэл юм. Англи хэлийг гурван жилийн турш бие дааж сурахдаа өөрийн арга барилтай болсон тул бусад хэлд жилээс бага хугацаа зарцуулж иржээ. Түүний гол арга нь унших байсан тул өөрийн сайн мэддэг Эртийн Грекийн үлгэр домгийн сурах хэл дээрээ худалдан авдаг байжээ. Англи хэл сурахын тулд Гомерын "Илиад" баатарлаг туульсийг англиар, англи хэлний дүрмийн ном, англи герман хэлний толь авчээ. Ингээд унших аргыг хэрхэн бүтээлч үйл ажиллагаа болгож чадсаныг нь дэс дараалалтайгаар авч үзье.

1. Илиад зохиолын аль нэгэн бүлгийг хэд дахин чангаар уншдаг байжээ. Текстлг уншиж цээжлэнэ. Уншиж байгаа зохиолоо өөрөө сайн мэддэг байсан тул амархан цээжлчихдэг байжээ.

2. Цээжлсэн текстээ толгны өмнө зогсоод өөрөө өөртөө ярьж өгнө.

3. Дараа нь цээжлсэн текстээ бичнэ.

4. Бичсэн текстээ зохиолтойгоо харьцуулан үзнэ. Хэрэв 70 хувиас доош тогтоосон байвал дахин уншдаг байжээ. Харин хоёрдахь удаадаа толгны өмнө зогсолгүй гадгшаа гарч гудамжинд сууж байгаа гуйлагчин дээр очоод: "Би чамд юм ярьж өгье. Сонсоны чинь шанд едрийн хоол авч өгье" гэж хэлээд текстээ ярьж өгдөг байжээ. Зарим хүн өөрийнх нь өт мэдэхгүй хэлээр юм яриад байхад унтчихдаг байсан гэж едрийн тэмдэглэлдээ бичиж үлдээсэн байна.

5. Цээжлсэн текстээ өөрийн үгээр ярина.

6. Текстээ цээжлээд, бичээд, өөрийн үгээр өөрөө өөртөө ярьсаныхаа дараа Амстердам хотын далайн боомт руу явж англи усан цэргүүд дээр очоод тэдэнд ярьж өгдөг байжээ. Тогтоосон текстээ англи хэлтэй хүнд ярьж өгнө.

7. Усан цэргүүдэд текстээ ярьж өгснөө дуудлагаа засуулж аваад тэд нараар өөрсдөөр нь уншуулж араас нь дагаж хэлдэг байжээ. "Үйдсэн усан цэргүүд дээр очоод Эртийн Грекийн үлгэр домгоос ярьж өгөхөд уншаагүй хэсэг нь сонирхож дахин ирж сонирхолтой зүйлээсээ ярьж өгөрдөг гэхээр нь бичиж очоод өөрсдөөр нь чанга уншуулаад анхааралтай сонсдог байсан" гэж тэмдэглэлдээ бичиж үлдээсэн байна.

8. Хамгийн сүүлд текстийн үг хэллэгийг ашиглан харицгаа яриа зохиогоод англи хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг сүм дээр очиж хүмүүстэй уншсан текстийнхээ тухай харицна ярилцдаг байжээ. Харицгаа яриа зохиохдоо хэлний дүрмийг судалдаг байв. Шлиман англи хэлний хорь гаруй цагийг ойлгох гэж өөрийгөө зовоогоогүй харин хамгийн түрүүнд дүрмийн бус үйл үсийг цээжилсэн гэж цохон тэмдэглэсэн байна. Тэр эхлээд харицгаа яригаа өнгөрсөн цаг дээр зохиодог байжээ.

Дараа нь тэр яригаа одоо болж буй цаг буюу ирээдүй цаг дээр тус тусад нь хувиргаад өөрийн болгосны дараа өөр цагууд руу аажмаар оржээ байжээ. Ийм

найман үйлдлийг уйгагүй хийж байж англи хэл сурчээ. Өнгөц харахад энэ нь сунжирсан үйл явц мэт харагдах боловч уурат тархийг идэвхтэй ажиллуулж сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх үр өгөөжтэй арга мөн юм. Ингэж ажилласнаараа найман удаа ойр ойрхон үр дүнгээ хүрдэн харж хэл сурах явцыг сонирхонтой бүтээлч үйл ажиллагаа болгож чаджээ. Өөрөөр хэлбэл Шлиманы арга гэдэг нь гадаад хэлийг богино хугацаанд эрчимтэйгээр тасралтгүй дайрч бүтээлээр үзэхийг хэлж байгаа юм. Шлиманы энэ арга нь ямар учраас хэл шинжлэлийн ухаанд бие дааж сурах шалгарсан арга болсон тухай хэдэн үг хэлнэ. Аливаа гадаад хэл сурахад бичих, унших, ярих, сонсох ба орчуулах аргыг хэрэглэдэг. Бид багшаар хэл заалгаж байхдаа эдгээр таван аргаас унших, бичих, орчуулах гуравт их анхаарагддаг байсан. Энэ нь бид нар нүд гар хоёроо ихээр хэрэглэдэг байсан гэдгийг хэлж байгаа юм. Гэтэл Шлиман харах, сонсох, бичих мэдрэмжүүдээ нэгэн зэрэг хэрэглэж маш их чармайлт гарган сурдаг байжээ. Өөрөөр хэлбэл текстийг амандаа биш чангаар уншихад нүд, ам, чих зэрэг ажиглагчид. Гараа хамгийн сүүлд хэрэглэдэг байжээ. Бие даан сурч байгаа хүн текстийг чангаар уншиснаар хүрд ан тогтоодог гэдгийг Шлиманы арга харуулж байгаа юм. Санхүүгийн боломжийг аль эсвэл бусадтай хамт сурах цаг завгүй хүн алдаагаа засуулах бүхий л боломжийг хайх хэрэгтэй. Өөрийн сайн мэддэг зүйлээ хүний сонирхолыг татахуйц ярьж чадвал алдаа засаад өгөх хүн хаа сайгүй байдаг юм байна гэдгийг Шлиманы аргаас суралцах боломжтой. 1983 онд ЗХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн хүрээлэнд аспирантаар суралцаж байхад минь ЗХУ-ын Аюулаас хамгаалах Яамны сургуулиас тэтгэвэрт гарсан багш бидэнд герман хэл зааж байсан. Багш маань бидэнд Шлиманы аргыг сургууль дээрээ хэсэгхэн хугацаанд яаж хэрэглэдэг байснаа тайлбарлан өгч билээ. Хүн бүрийн юм тогтоох арга бодил өөр өөр байдаг тул сургалтынхаа эхний үед оюутнууд дээрээ энэ аргыг хэрэглэж тогтоох чадварыг нь илрүүлдэг байсан гэж багш маань ярьж байсан.

Зарим хүн ямар нэгэн юмыг нэг сонсоод л тогтоочихдог бол мянган удаа хэлээд байхад тогтоодоггүй хүн бас байж л байдаг. Зарим хүн нэг харсан юмаа хэзээ ч мартдаггүй бол зарим нь нь нүдэнд дээр байгаа юмаа олж хардаггүй. Иймээс тагнүүлчдыг бэлтгэдэг сургууль нь гадаад хэлийг өдөр бүр 4 цагаар эрчимтэйгээр заахдаа оюутнуудынхаа тогтоох чадвар, сэтгэн бодох чадвар болон хүнтэй харьцах харилцааны ч соёлыг Шлиманы аргаар нэгэн зэрэг богинохоно хугацаанд шалгарчигдахдаг байжээ. Гөрих Шлиман нь гадаад хэлийг зорилго гэж үзэлгүй харин зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болгож чадсан хүн учраас түүний аргыг тэр сургуулийнхаа хэрэглэдэг байсан гэж багш маань хэлдэг байсан. 1001 шөнийн үлгэр байдалтай адил гадаад хэлийг бие даан сурах 1001 арга байдаг гэж хэлж болно. Хүн бүр өөр өөрийн аргаар суралцдаг гэж эхэлсэн билээ.

Судалгааны хэсэг


1. Сурагчидаас англи хэлийг хэдэн жил сурч байгаа вэ гэж асуухад
 - А. Сурч байгаагүй
 - Б. 3-5 жил
 - В. 5 дээш

1. Сурагчидаас англи хэлийг хэдэн жил сурч байгаа вэ гэж асуухад



2. Та англи хэлний чадвараа өөрөө үнэлвэл
 - А.1 буюу үсгээ сайн мэдэхгүй
 - Б. 2 буюу цөөн тооны үг мэднэ
 - В. 3 буюу өгүүлбэр зохиож асууж бага зэрэг чадна.
 - Г. 4 Чөлөөтэй ангилиар ярьж бичиж чадна.

1. Та англи хэлний чадвараа өөрөө үнэлвэл



3. Танд англиар ярихад ямар бэрхшээл гардаг вэ?


А. Үг мэдэхгүй

Б. Бусад ангийн суралцагчид сонсоод шоолох вий гэхээс ичдэг

В. Үгээ ямар дараалаар хэлхээ мэдэхгүй

Г. Ямар цаг дээр хэлхээ мэдэхгүй

1. Танд англиар ярихад ямар бэрхшээл гардаг вэ?



4.Таньд англи хэл сурхад аль нь хэцүү вэ?

А. Унших


Б. Бичих

В. Дүрэм

Г. Ярих

Таньд англи хэл сурхад аль нь хэцүү вэ?

■ А. Унших ■ Б. Бичих ■ В. Дүрэм ■ Г. Ярих



5. Та англи хэлийг аль хэмжээнд сурхыг хүсч байна вэ?


А. Тийм ч чухал биш.

Б. Өөрийн мэргэжлийн хүрээнд

В. Цаашид гүнгийрүүлэн


Та англи хэлийг аль хэмжээнд сурхыг хүсч байна вэ?

■ А. Тийм ч чухал биш. ■ Б. Өөрийн мэргэжлийн хүрээнд ■ В. Цаашид гүнгийрүүлэн




2. Туршилтын аргаар Техникчийн **ХАБ-1А** ангид шалимены аргыг хэргэлж **Marco Polo** сэдвээр хичээл заасан. Техникчийн ХММ-ын ангид энэ сэдвээр хичээл зааж харьцуулалт хийж үзлээ.


1. Шалимены аргын дагуу **унш унш** бас дахин унш гэсэн арыг хэргэлэн Сурагчидын тухайн техстийг өөрөө эхэлж уншаад дараа нэг нэгээр уншуулаад дуудлага болон шинэ үгийг нь зааж дахин 5-6 удаа уншуулж байгаад цээжлүүлэн өөрөөр нь яриулсан. Үүний үр дүнд сурагчидын дуудлага болон үг цээжлэлт хэр дээрдсэнийг дараах графикаар харууллаа.
Дээрхи текстээс мэдсэн үг санаж байгаагаа бич гэхэд шалимены аргыг хэргэлсэн аргыг хэргэлсэн анги шалгалтан маш өндөр үнэлгээ авсан бана. Хамгийн бага үг хамгийн их үгээр нь графиклав



2. Дараа уншиж цээжилсэн текст дээрээ past simple цагийг тайлбарлан асуух хариулах хэлбэр дээр өгүүлбэр тус бүрээр зохиож бас дахин уншин түүнийгээ ярьж асуугдсан. Нөгөө ангид зүгээр энэ цагийг заагаад дасгал ажил ажилуулсан юм. Past simple цагаар шалгалт авхад Шалимены аргыг хэргэлэн асуух хариулт зохиож ярьсан анги бас л илүү өндөр үнэлгээг авсан.



3. Хамгийн сүүлд текстэн дээр үгнүүдийг ашиглан өгүүлбэр зохиолгов тэдний өгөрсөнд хийсэн аялалын тухай. I travelled to UB by taxi with my parents гэх мэт. Нөгөө ангид нь өөр сэдэв үзэв. Зохион бичлэгийн оноогоор жагсаавал.



Дүгнэлт

Хүн болгон өөр өөрийн сурах арга барилтай ч хүн бүгдэд таарсан аргаар заах хэцүү гэлцүү тэдний ихэнх нь тохирсон аргыг ашиглан хичээл заах нь багш бидний хамгийн чухал амжилт шүү дээ. Би энэхүү судалгааг хийснээр Шлапменний аргыг туршиж сурхаас гадна энэхүү аргын давуу талыг дүгнэн бичлээ.

- Ихэнх хүмүүс мөн би ч бас гэсэн гадгад хэл сурч байхдаа улаан эрээгээр нь дэвтэр дээрээ бичээд түүүнийгээ энд тэнд нааж үгээ цээжлгдэг байсан харин гадгад хэл сурхын тулд маш их уншуулж цээжлүүлэх хэрэгтэй.
- Суралцдыг чангаар уншуулах нь дан ганц дуудлага сайжруулж үгийн санг нэмхээс гадна сонсголыг бас давхар сайжруулж байна.
- Суралцдаар уншуулж цээжилсэн текст дээр тийм ч урт байх шаардлаггүй тулгуурлан өгүүлбэрийг цагуудаар хувирган асуух хариулах баттах өгүүлбэр зохиологх тэдний нарын хувьд маш сонирхолтой байсан ба тухай үзэж байгаа цагаа маш сайн ойлгосон төдийгүй буцаагаад ярихад ч илүү хялбар байсан.

Жишээ нь: He travelled over icy and snowy mountains
He didn't travelled icy and snowy mountains
Did he travel icy and snowy mountains?

- Суралцдыг сурсан шинэ үгийг ашиглан прагмид ашиглан өгүүлбэр зохиологх нь маш үр дүнтэй.

Жишээ нь: I travelled

I travelled to UB

I travelled to UB with my parents

I travelled to UB with my parents' last summer гэх мэт энэ арга нь

суралцачийн үгийн баялагыг нэмэгдүүлэхээс гадна суралцагчийн ярианы баялыг нэмэгдүүлэхэд маш тустай байсан.

Үг хэрхэн цээжлэх вэ?

Мэдээж үгийн баялаг хэл сурахад маш чухал. Ихэнхи хүмүүс гадаад хэл сурч байх явцдаа үг цээжилдэг ерөнхий ганцхан аргатай байдаг. Дэвтэр дээр нэг далд нь англи үгээ нөгөө талд нь Монгол орчуулгыг нь улаанаар жагсаагаад энд тэндгүй гэрийнхээ ханан дээр, гал тогооны өрөөнд, орныхоо толгой дээр гэх мэт өдөр бүр чамтай байнга тааралддаг эд зүйлс дээрээ тогтоон байрлуулдаг. Гадаад хэлийг амжилттай сурч чадсан ихэнхи хүмүүсийн дүгнэж байгаагаар энэ нь тийм ч үр дүнтэй үг цээжлэх арга биш юм гэдэг. Тийм болохоор хамгийн шилдэг үг цээжлэх аргуудаас та бүхэндээ товчхон хүргэхийг зорьлоо.

1. ***Read as much as you can:*** Чадах чинээгээрээ аль болох маш их унших хэрэгтэй. Англи хэл дээр сонин сэтгүүл ном унших таны үг цээжлэх үгийг нүдлэх хамгийн сайн аргуудын нэг яах аргагүй мөн. Та уншиж байгаа ном сонин сэтгүүлээ эхний удаа ойлгохгүй байж болно. Үүнд та нэг их санаа зовж, өөрийгөө голох хэрэггүй. Дахиад л унш. Өөр олон ном, сэтгүүл унш. Тэр болгонд танд маш олон шинэ үгнүүд нүдлэгдсээр байх болно. Хүмүүс аливаа зүйлийг явц дунд, практик дээр илүү сайн сурдаг гэж ярьдаг шүү дээ. Тэгвэл баахан үг жагсааж бичээд түүнийгээ автоматаар цээжлэхээс уншиж, бичиж байх явцдаа шинэ үг олж, тэдгээр үгнүүдийг

2. Use a good dictionary: Хамгийн сайн толь бичгийг ашиглах хэрэгтэй. Харин таны ашиглаж байгаа толь бичиг чинь хоёр хэл дээр байх ёсгүй. Нэг үгээр бол Англиас Монгол уруу, Монголоос Англи уруу биш Англи үгийг англиар тайлбарласан байх ёстой. Би англи хэл сайн мэдэхгүй байж яаж Англи үгийг Англиар ойлгох юм бэ? гэж та гайхаж магадгүй. Тэдгээр толь бичигүүд нь дотроо түвшингээрээ англилагдсан байдаг. Эхлэн суралцагчдад зориулан энгийн үг хэллэгээр тайлбарласан мөн дунд шатныханд зориулсан гэх мэтчилэн. Бүгдээрээ жишээ авч үзье. Banana гэдэг үгийг Англиар тайлбарлавал: Banana- is a long yellow fruit what is growing in tropical area. Банана жимс бол халуун оронд ургадаг урт шар жимс юм. Маш энгийнээр өөрт ойлгогдох үг хэллэгийг сонгон тайлбарласан байна. Англи үгийг хайж байхдаа Англиар уншиж байна. Энэ бол хамгийн үр дүнтэй үг цээжлэх, цаашилбал ярьж сурах арга юм.

3. Learn from your listening: Англи хэл дээр телевизийн сайн хөтөлбөр үзэх, радио нэвтрүүлэг үзэх, ду сонсох нь таны сонсголыг хөгжүүлэхээс гадна үг цээжлэх бас нэг сайн арга юм. Тэр тусмаа дуу сонсох арга бол хамгийн энгийнээр сонсголоо хөгжүүлэх мөн хэллэгээ сайжруулах шалгарсан арга юм.

4. *Make your own word list:* Өөрийн гэсэн

толь бичиг, үгийн санг дэвтэр дээр бүтээх хэрэгтэй. Хуудас бүр дээр 26 үсгээ тавиад мэдэхгүй байгаа Англи үгээ үсэг бүр дээр нь бичнэ. Энд ганцхан зүйлийг анхаарах хэрэгтэй. Дээр хэлснээр Англи үгийг Англиар дээр нь тэмдэглэх хэрэгтэй. Өөрийн мэддэг үгээр бүтсэн өөрийнхээ өгүүлбэрээр тэр үгээ тайлбарлах хэрэгтэй. Ингэж чадвал та үг хурдан тогтоож, Англиар ярьж сурах, цаашилбал бичиж сурах хоёр дахь алхамаа хийлээ.

5. *Use your new words everyday:* Өөрийн сурсан, нүдэлсэн үг бүрийг та өдөр тутам ашиглах хэрэгтэй. Шинэ үг бүрийг аль болох бусдад хэлж өгөх өөрөө ашиглахыг ямагт оролдох хэрэгтэй. Хэрвээ та Англи хэл сурна гэж үнэхээр шийдсэн бол цаг бүү алд. Сурсан үгээ ганц минутын дараа эргэж хараад л амьдралд туршиж үзэхийг оролд. Бусдад зааж өг. Ийм үед танд ичэх гэдэг ойлголт байх ёсгүй. Англи хэл сурах хамгийн үр дүнтэй, хамгийн үнэнд ойрхон аргуудыг та бүхэндээ дэлгэлээ.